

ХЯТАДЫН ХӨГЖЛИЙН ШИНЭ ҮЕ ШАТ, ШИНЭ ХЭВ ЗАГВАР

Ц.Батбаяр*
М.Энх-Амгалан**

ХКН-ын 17 дахь удаагийн сонгуулийн Төв хорооны 5 дугаар бүгд хурал 2010 оны 10 дугаар сарын 15-18-ны өдөр хуралдав. Тус бүгд хурлаар БНХАУ-ын ирэх 2011-2015 оны шинэ 5 жил болох 12 дугаар 5 жилийн төлөвлөгөөний агуулга, үзэл санааг хэлэлцэв. Тус бүгд хурлын тухай албан мэдээнд дурдсанаар ирэх 5 жилийн төлөвлөгөөнд эдийн засаг, нийгмийн салбарт дараах үндсэн зорилтуудыг тусгахаар болсон байна.¹ Үүнд:

Эдийн засаг-нийгмийн салбарт

- Дотоод эрэлт, хэрэглээг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг хөрөнгө оруулалт, экспорт, дотоод хэрэглээ хосолсон хэлбэрээр хөгжүүлэх,

- Хүн амын орлогыг нэмэгдүүлэх, төрөөс баялгийг иргэн бүрт тэгш хуваарилах

- Эрчим хүчний шинэ эх үүсвэрийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх,

Ядуурлыг бууруулах, орон нутгийн хөгжлийг хангах чиглэлд

- Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах, хөдөө орон нутгийг цогцоор нь хөгжүүлэх,

- Иргэдэд үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн халамж, боловсрол зэрэг төрийн үйлчилгээг сайжруулах,

ХКН-ын төв хэвлэл “Жэньминь Жибао” сонинд бичсэнээр “Хятадын нэг хүнд ноогдох ДНБ 4000 ам.долларт дөхөж ирж байгаа, үүнтэй уялдан өөрчлөлт шинэчлэлтийн үйл явцад цоо шинэ асуудлууд гарч ирж байна. 30 гаруйхан жилийн хооронд бид бусад улсуудын бүхэл бүтэн зуун жилд туулдаг замыг хурдавчлан туулж ирлээ. Нийгмийн бүтцэд гарсан гүнзгий өөрчлөлт, ашиг сонирхол, үзэл санааны салбарт гарсан түргэн өөрчлөлтүүд нь шинэ зөрчил, шинэ асуудлуудыг төрөн гаргалаа” гэж бичжээ.² Өнгөрсөн 2009 онд Хятадын ДНБ 33,54 их наяд /триллион/ юаньд хүрсэн тухай Хятадын статистикийн газар мэдээлсэн. Бусад хөгжиж буй орнуудын туршлагаас үзвэл тухайн орны нэг хүнд ноогдох ДНБ 4000 ам.долларт хүрнэ гэдэг нь хөгжлийн нэгэн заагт хүрснийг илтгэж буй бөгөөд цаашдын эдийн засгийн өсөлтийн хэв загварыг шинээр харах шаардлагатай ажээ. Хятадын эдийн засаг сүүлийн 30 гаруй жилийн турш гадаадын хөрөнгө оруулалт, экспортод хэт түшиглэн хөгжиж ирснээр тус улсын дотоод хэрэглээний ач холбогдол, өсөлт буурсан байна. Ирэх 12 дугаар 5 жилийн төлөвлөгөө нь үндсэн агуулгаараа тус улс дотоод хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэх ажээ.

Тус улс нь 2009 оны байдлаар дэлхийн нийт нүүрсний хэрэглээний 46 хувь, дэлхийн цайр, хөнгөн цагааны хэрэглээний мөн 40 орчим хувийг дангаараа эзэлж байна. Хятад улсын жилийн нүүрсний хэрэглээ 2000 онд 1,24 тэрбум тонн байсан бол 2008 онд 2,83 тэрбум тонн болж өсчээ.

* Ц.Батбаяр - Түүхийн шинжлэх ухааны доктор

** М.Энх-Амгалан - Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны 3-р нарийн бичгийн дарга

Үүнийг дагалдан сульфид диоксид бохирдолын ялгаруулалтын хэмжээ 2000 онд 20 сая тонн байсан бол 2005 онд 25,5 сая тонн болж нэмэгдсэн байна. Иймээс шинэ 5 жилийн төлөвлөгөөнд ашигт малтмалын хэрэглээг хязгаарлах, байгаль орчны хамгаалалтыг чангатгах заалтууд багтжээ. Тухайлбал, ДНБ-ний нэг нэгжид ноогдох хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2020 он гэхэд 2005 оныхтой харьцуулахад 40-45 хувиар бууруулах амлалтыг Хятад улс хүлээсэн байгаа. Түүнчлэн нийт цахилгаан эрчим хүчний балансад нөхөн сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийн жинг 2010 онд 15 хувьд, 2020 онд 20 хувьд хүргэх зорилт дэвшүүлсэн.³

Хятад улс нь өнөөдөр дэлхийн эрдэс баялгийн хамгийн том зах зээл болоод байна. Тухайлбал Бразилийн экспортын 12.5 хувь, Өмнөд Африкийн экспортын 10.3 хувь, Австралийн экспортын 21.8 хувийг эзэлж байна. Энэ нь дэлхийн ашигт малтмал, түүхий эд экспортлогч голлох орнуудын экспорт Хятадын эрэлтээс шууд хамаарч байгааг илтгэж байна. Энэ байдал нь тус улсыг дэлхийн “үйлдвэр”-ээс дэлхийн “хэрэглэгч” болгох хандлага руу хөтөлж байна.

Тус улсад насжилт явагдаж, боловсролтой, чадвартай ажилчдын тоо ихсэж буйтай холбогдон цалин, тэтгэврийн хэмжээ ихсэж байна. Хятадын муж, хотуудад ажилчдын доод цалинг 5-27 хувиар нэмсэн байна. Мөн үйлдвэрлэл түлхүү хөгжсөн Хятадын өмнөд хэсгийн зарим үйлдвэрт цалин багатайгаас болон ажилчид амиа хорлох нь нэмэгдсэнээс шалтгаалан зарим үйлдвэр цалингаа 66 хувиар нэмсэн. Цаашид ажилчдын цалин тогтмол нэмэгдэх хандлага давамгайлж байна.

Хот суурин газрын ба хөдөө, орон нутгийн иргэдийн “орлогын ялгаа” ихсэв. Энэхүү ялгааг мөн эргийн хотууд ба эргийн бус хотуудын хөгжлийн ялгаатай адилтгаж үзэж болно. Үндэсний статистикийн газрын тоо баримтаас үзвэл Хятадын хотын оршин суугчдын бодит орлого 2009 онд 17,175 юань буюу 2533 ам.доллар байсан бол хөдөө орон нутгийн 700 сая гаруй оршин суугчдын орлого 5153 юань буюу 760 ам.доллар байжээ. НҮБ-ын амьжиргааны хамгийн бага орлого өдөрт 1,5 ам.доллараар амь зогоох жишгээр аваад үзсэн ч Хятадын хүн амын 10 хувь нь нэн ядуу нөхцөлд амьдарсан хэвээр байна гэжээ.⁴ Иргэдийн орлогын ялгаа ихэссэнээр эрүүл мэнд, боловсрол, зээл авах, төрийн бусад үйлчилгээнд хамрагдах “боломжийн ялгаа”-г мөн үүсгэж байгаа ажээ. Мөн хөдөлмөрийн насны иргэд ажил хайхаар хот сууринд шилжин ирж буй нь хүрээлэн буй орчин, хот төлөвлөлт зэрэг олон хүндрэлүүдийг үүсгэж байна.

2009 оны хоёрдугаар хагасаас эхлэн эдийн засгийн өсөлтийн удаашрыг зогсоож чадсан. Эдийн засгийн өсөлтийн хурд 2009 онд 9,1%, харин 2010 оны эхний хагаст 11,1% болсон. Хот суурин газрын ажлын байрны асуудал хэвийн болж, иргэдийн орлого өсч нийгмийн тогтвортой байдал хадгалагдсан. Хятад шиг 1,3 тэрбум хүн амтай улсад эдийн засгийн тогтмол өсөлтийг хангахгүй бол бүх иргэдийг ажлын байртай байлгах асуудал хоосон үгтэй адил гэж БНХАУ-ын удирдлага тооцож байна. Санхүүгийн хямралаас гарах багц төлөвлөгөө нь зөвхөн одоо байгаа эдийн

засгийн өсөлт болон нийгмийн тогтвортой байдлыг хадгалахаас гадна хамгийн чухал нь эдийн засгийн цаашдын хөгжлийн таатай орчинг бүрдүүлж өгсөн гэж үзэж байна.

Олон улсын санхүүгийн хямралтай тэмцэхэд Хятад улс эдийн засгийн хөгжил болон шинэчлэлд анхаарал хандуулж ирсэн. Сүүлийн хоёр жилд дотоодын эрэлт хэрэгцээ нь эдийн засгийн өсөлтийг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Жижиглэн худалдааны нийт хэмжээ 2009 онд 16,9 хувиар өссөн. Энэ нь 1986 оноос хойшхи хамгийн хурдан өссөн үзүүлэлт юм. Энэ таатай нөхцөл байдал үргэлжлэн 2010 оны эхний хагас жилд мөн хурдаар өссөн байна. Үйлдвэр аж ахуйн бүтцийн шинэчлэлт хурдассан. Энэ оны эхний 7 сард өндөр технологийн салбар 17,7 хувиар өсч, дэд бүтцийн хөгжил сайжирсан. 2008 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс Бээжин-Тяньжин чиглэлийн хот хоорондын төмөр замаар анх удаа нэгдүгээр зэрэглэлийн хурдны галт тэрэг явж эхэлсэн. Бээжин-Тяньжины чиглэлд явах хугацаа 30 минут болсон. Байгаль орчин хамгаалал, хаягдал багасгах, эрчим хүчний хангалтын чиглэлд мэдэгдэхүйц амжилтанд хүрсэн.

Нөгөө талаас санхүүгийн хямралтай холбогдуулан Хятадын банкуудын зээлийн хэмжээ ихээхэн өссөн билээ. Хятадын арилжааны банкууд 2009 онд 9,6 их наяд /триллион/ юань буюу 1,4 их наяд ам.доллартай тэнцэх зээлийг олгосон нь 2008 онд олгосон нийт зээлээс бараг нэг дахин их болжээ.⁵ Хятадын төв банк инфляцийн түвшинг хязгаарлах, зах зээл дээрх мөнгөний хэтэрсэн нийлүүлэлтийг хумих, үл хөдлөх хөрөнгийн үнийн өсөлтийг намжаах зорилгоор төв банкны бодлогын хүүг нэмэх, инфляцийн түвшин өнгөрсөн 3 жилийн дотор хамгийн өндөр буюу 3.5 хувьд хүрснээс болж арилжааны банкнуудын заавал байх нөөцийг нэмэгдүүлэх, арилжааны банкны хадгаламжийн хүүг нэмэх замаар мөнгөний нийлүүлэлтийг хумих зэрэг макро эдийн засгийн зохицуулалтыг 2010 оноос ихээр хийх болсон. Дэлхийн санхүүгийн систем дэх улс орнуудын харилцан хамаарал улам бүр ихсэж буй тул ирэх 5 жилийн төлөвлөгөөнд макро эдийн засгийн хяналт, зохицуулалтын асуудал чухлаар тавигдах бололтой.

Хүлэмжийн хий бага ялгаруулдаг эрчим хүчний эх үүсвэрүүдийн талаар судалгаа хийж, амьдралд нэвтрүүлэхэд Хятадын Засгийн газрын анхаарч байна. Тухайлбал нар, салхины эрчим хүч, цахилгаанаар ажилладаг автомашин үйлдвэрлэлийн салбарт төрөөс чухал ач холбогдол өгч байна. Хүнд үйлдвэрлэлийн салбар нь ажлын байр бага бий болгодог, хүрээлэн буй орчинд хортой зэрэг байдал нь ирэх 5 жилийн төлөвлөгөөнд хүнд үйлдвэрлэлийн салбарын харьцааг багагүй цэгцлэх, хүрээлэн буй орчинд хортой үйлдвэрүүдийг хаах, үйлдвэрлэлийг багасгах төлөвтэй байна.

11 дүгээр 5 жилийн төлөвлөгөөний хэрэгжилтээс үүдэн ирэх 5 жилийн төлөвлөгөөнд тусгах эдийн засгийн асуудлууд

1. ДНБ-ий хэмжээг тодорхойлохдоо олон хүчин зүйлийг харгалзана. ДНБ-ийг давуулан биелүүлэхийн тулд хүрээлэн буй орчин болон нийгмийн чухал зорилтуудыг тооцохгүй зөвхөн тооны хойноос хөөцөлдөх болсон. ДНБ-ий жилийн өсөлтийг бодит байдлаас багаар буюу

7.5 хувиар тогтоосон боловч үнэн хэрэгтээ тус улсын эдийн засаг 11.1 хувь хүртлээ өсөж байсан.

2. Тэнцвэртэй гадаад худалдааг дэмжинэ. Хятадын гадаад худалдааны ашиг 2009 онд 30 хувиар буурсан. Гэсэн хэдий ч Саудын Арабын дараа дэлхийд 2 дугаар байрт явсаар байна. Ирэх 2011 онд худалдааны ашиг тус улсын ДНБ-ий 4 хувьтай тэнцэх төлөвтэй байна. Гадаад худалдааны ашигтай байдал нь АНУ зэрэг худалдааны түнш орнуудтай худалдааны тэнцвэргүй харилцааг үүсгэж улмаар энэ салбарын харилцаанд ан цав үүсгэсээр байна. Ирэх 5 жилийн төлөвлөгөөнд худалдааны ашгийг ДНБ-ий 3 хувиас хэтрүүлэхгүй байх зорилт тавьж байна.

3. Юаны шинэчлэл. Хятад Улс дэлхий дахинд юаны ханшийг зохиомлоор дарах замаар гадаад худалдаанаас ашиг олж буй байдлаараа томоохон орнуудын шүүмжлэлийг хүлээж байгаа билээ. Хэдийгээр 2010 оны 6 дугаар сараас хойш тус улс долларын эсрэг юаны ханшийг 2 хувиар өсгөсөн боловч харин еврогийн эсрэг 12 хувиар, иений эсрэг 6 хувиар буулгасан байна.

4. Төрийн орлоог багасгана. Өнгөрсөн 5 жилийн турш төрийн өмчит компаниудын тоо цөөрсөн гэсэн хэдий ч тэдгээр компаниудын хөрөнгө 3 дахин өсч 3 триллион ам.долларт хүрсэн бөгөөд орлого нь 4 дахин өсч 1.9 триллион ам.долларт хүрч, ашиг нь 3 дахин өсч 122 тэрбумд хүрсэн. Хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд төр өөрийн орлогоо ард түмэнтэйгээ хуваалцах ёстой гэсэн хандлага давамгайлж байна.

Тяньжин хотод 2010 оны 9 дүгээр сард болсон Дэлхийн эдийн засгийн 4 дэх удаагийн зуны Давос форумыг нээж хэлсэн үгэндээ Хятадын Төрийн зөвлөлийн ерөнхий сайд Вэнь Зябао “бид богино хугацааны зохицуулалтын бодлого, урт хугацааны хөгжлийн бодлогоор өөрчлөн байгуулалтыг гүнзгийрүүлж шинжлэх ухаанч хөгжилд түлхэц өгч, Хятадын эдийн засгийг хөгжүүлнэ” гэсэн байна.

Тэрээр хэлэхдээ “бид ойрын ирээдүйд дараах чиглэлүүдэд хүчээ төвлөрүүлэх болно. Манай улс дотоод, гадаад тэнцвэртэй хөгжлийг баримталж, дотоодын хэрэглээгээ өсгөх ялангуяа хэрэглээнийхээ хэрэгцээ шаардлагыг өсгөх урт хугацааны дорвитой ажиллагаа бий болгох хэрэгтэй. Хятад улс бол дэлхийд хамгийн том дотоод зах зээлтэй улс бөгөөд дотоод зах зээлийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн гаргаж, дотоодын хэрэглээгээ үр дүнтэй чөлөөлж өгөх нь хятадын эдийн засгийн урт хугацааны, тогтвортой хөгжлийн гол зангилаа төдийгүй эдийн засгийн болзошгүй, гэнэтийн зөрчил, хямралыг шийдвэрлэх чухал зам юм. Бид орлогын хувиарлалтын тогтолцоон дахь өөрчлөлтийг түргэсгэж, иргэдийн орлогын хэмжээг нэмэгдүүлнэ. Энэ нь илүү олон хүнийг орлоготой болгож, орлогын зөрөө багасч, ард иргэдийн орлого болон хэрэглээ тогтвортой өсөх боломжтой. Бид хот хөдөөгийн хөгжлийг уялдуулж, эрчимтэй, найдвартай, тогтвортойгоор хотжих явцыг ахиулж, газар оронд нь тохирсон нөхцлөөр ажилчин, тариачныг хотжуулж суурьшуулах, шинээр байгуулж байгаа хот суурины бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх, хөдөө тосгодын дэд бүтэц, нийтийн үйлчилгээг сайжруулах, бүсийн хөгжлийн нэгдсэн цогц бодлогыг үргэлжлэн хэрэгжүүлж, баруун бүсийг

ихээр нээн хөгжүүлэх, зүүн хойд бүсийн хуучин аж үйлдвэрийн баазуудыг сэргээн хөгжүүлэх, төвийн бүсийн хөгжлийг ахиулах, дотоодын хэрэглээг өсгөх шинэ хөдөлгөх хүчийг дэмжих, хөдөө тосгон болон төв, баруун бүсийн дотоодын хэрэглээ өсөх шинэ орон зайг өргөжүүлэх хэрэгтэй. Үүний зэрэгцээ бид олон улсын болон дотоодын зах зээл рүү хандсан бодлого баримтлах хэрэгтэй” гэв.⁶ Өөрөөр хэлбэл, Хятад улс ойрын ирээдүйд өөрийн асар том дотоодын зах зээлийн нөөц бололцоог нээж хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулах нь тодорхой болж байна.

Вэнь Зябао мөн “Хятад улс бол нээлттэй эдийн засагтай улс. Манай улс хэдийгээр маш том экспортлогч улс боловч мөн маш том импортлогч орон. Гадаад худалдаа хөгжүүлэхдээ ашгийн хойноос огтхон ч хөөцөлддөггүй. Өнөөгийн байдлаар манай улсын Америк, Европтай хийж буй худалдаа ашигтай байгаа бол Япон, Өмнөд Солонгостой хийж буй худалдаа алдагдалтай байна. Экспортын сэргэлт хурдан байгаа боловч импортын өсөлт илүү хурдан байна. Бид хаалгаа түгжиж аваад хөгжөөд байж болохгүй, тийм боломж ч байхгүй. Дотоодын хэрэглээгээ өсгөхийн зэрэгцээ гадаад хэрэглээгээ мөн идэвхитэй, тогтвортой өсгөж, гадаад, дотоод тэнцвэртэй хөгжлийг хангана. Шинийг эрэлхийлж, шинжлэх ухааны дэвшил гаргаж, үйлдвэрлэлийн чанарыг сайжруулах талаар чармайлт гаргах хэрэгтэй. Шинжлэх ухаанчаар шинийг эрэлхийлэх болон орчин үеийн үйлдвэрлэлийн тогтолцоог нэгтгэж, сүүлийн үеийн шилдэг технологиор хуучны уламжлалт үйлдвэрлэлээ шинэчилж, өөрсдийн оюуны эрхийн өмчлөл бүхий нэртэй бренд бүтээгдэхүүнтэй болох мөн олон улсад өрсөлдөх чадвартай шилдэг аж ахуй, үйлдвэрүүдийг дэмжих, олон улсын стандартад хүрсэн, үлгэр жишээ үйлдвэрлэгч компани, корпорациудыг дэмжиж “их Хятад улсыг хүчирхэг Хятад улс” болгох хэрэгтэй. Бид ирээдүйд шинжлэх ухааны шинэ чиг хандлагуудыг эзэмшиж, хөгжлийн бодлогын чанартай шинэ үйлдвэрүүдийг төрийн бодлогоор дэмжих, хөгжлийн тулгуур багана үйлдвэрүүдийг бий болгож үсрэнгүй хөгжих болно” гэжээ.⁷

БНХАУ-ын 12 дугаар 5 жилийн төлөвлөгөө нь ерөнхийдөө иргэн нэг бүрийн ахуй, амьдралыг сайжруулахад буюу БНХАУ-ын дарга Ху Жинтао-гийн анхлан тодорхойлсон хүн бүрт хүртсэн хөгжил буюу “Inclusive development”-ийн үзэл санааг ирэх 5 жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Өөрөөр хэлбэл эдийн засаг хэдэн хувийн өсөлттэй хөгжсөн бэ гэдэг агуулгаас илүүтэй иргэдийн орлого хэрхэн нэмэгдэв, хүрээлэн буй орчны бохирдол хэрхэн багасав гэдэг утгаар нь төлөвлөгөөг дүгнэх юм байна.

Экспортыг хөхиүлсэн, хямд ажиллах хүчинд тулгуурласан өсөлтийн хэв загвараас дотоодын зах зээлийн эрэлт, хэрэглээг нэмэгдүүлэх, экспорт, импорт, хөрөнгө оруулалтыг жигд тэнцвэртэй хөгжүүлэх, дотооддоо технологийн шинэчлэл, инновац хийхийг урамшуулан дэмжих, хотжилт суурьшлыг шинжлэх ухаанчаар хөгжүүлсэн хөгжлийн шинэ загварт шилжихийг ирэх 5 жилийн гол агуулга болгож байна.

Барууны хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ч ирэх 5 жилийн төлөвлөгөө нь тус улсын эдийн засаг тооноос чанарт, үсрэнгүй хөгжлөөс тогтвортой хөгжилд шилжих цаг хугацааг хамрана гэж бичиж байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. “Жэньминь жибао” сонин, 2010.10.28.
2. “Жэньминь жибао”, 2010.10.25.
3. Zhang Shiqu. Seeking Balance: Reconciling Nature and Development. “Global Asia” journal of the East Asia Foundation, Vol. 5, No 2, summer 2010, pp. 42-43.
4. Yang Wenchang. A Developing Country- Rational Identity of China. “Foreign Affairs Journal” by the Chinese People’s Institute of Foreign Affairs, No 97, autumn 2010, pp. 36-37.
5. Asian Wall Street Journal, 18 January 2010.
6. “Жэньминь жибао”. 2010.09.04.
7. Мөн тэнд